

**АШИГЛАЛТАД ОРСОН СУУЦНЫ ТУСДАА БАЙШИН, БИЕ ДААСАН ТОХИЛОГ СУУЦ БОЛОН НИЙТИЙН БАЙРНЫ
20.... ОНЫ ХАГАС, БҮТЭН ЖИЛИЙН МЭДЭЭ**

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Үзүүлэлт	Нэр	Код
Аймаг, нийслэл		
Сум, дүүрэг		
Баг, хороо		
Хаяг /хашаа, хаалганы дугаар/		
Байршил		
Уртраг		
Өргөрөг		

1. Баг, хорооны Засаг дарга нар өөрийн нутаг дэвсгэрт шинээр ашиглалтад орсон сууцны тусдаа байшинг болон нийтийн байрны мэдээг барилга нэг бүрээр гаргаж жил бүрийн 7, 1 дүгээр сарын 10-ны дотор сумын ЗДТГ, дүүргийн статистикийн хэлтэст маягтаар хүргүүлнэ.
2. Сумын ЗДТГ, дүүргийн статистикийн хэлтэс жил бүрийн 7, 1 сарын 20-ны дотор аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт цахим хэлбэрээр хүргүүлнэ.
3. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар жил бүрийн 7, 1 дүгээр сарын 25-нд Үндэсний статистикийн хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2. НИЙТ ӨРТӨГ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР, мян.төг

Үзүүлэлт	МД	Дүн
А	Б	1
Нийт өртөг <i>Мөр 1 = Мөр (2:6)</i>	1	
Эх үүсвэрээр:		
Өөрийн орлого, хөрөнгө, хадгаламж	2	
Банкны зээл	3	
Бусад зээл	4	
Бусдын тусламж	5	
Бусад	6	

3. АШИГЛАЛТАД ОРСОН БАЙШИН/ БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлт	МД	Сууцны тусдаа байшин	Бие даасан тохилог сууц	Нийтийн байр
А	Б	1	2	3
Нийт сууц <i>Мөр 1 = Мөр (2:8)</i>	1			
Өрөөний тоогоор:				
1	2			
2	3			
3	4			
4	5			
5	6			
6	7			
7, түүнээс олон	8			
Давхрын тоо	9			
Нийт талбай, кв.м <i>Мөр 10 = Мөр (11:13)</i>	10			
Зориулалтаар:				
Сууцны	11			
Үйлчилгээний	12			
Авто зогсоолын	13			
Цэвэр усны хангамж	14			
Халуун усны хангамж	15			
Ариун цэврийн байгууламж	16			
Халаалтын эх үүсвэр	17			
Цахилгааны эх үүсвэр	18			
Дулаан авто зогсоолын тоо	19			
Тоглоомын талбайн хэмжээ, кв.м	20			
Ногоон байгууламжийн хэмжээ, кв.м	21			
Өмчийн хэлбэр	22			

Мэдээ гаргасан: /...../

(гарын үсэг) (нэр)

Албан тушаал:.....

Хянасан: /...../

(гарын үсэг) (нэр)

Албан тушаал:.....

(А-ОС-3) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Энэхүү маягтаар тухайн тайлант хугацаанд ашиглалтад шинээр орсон сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, нийтийн байрны мэдээллийг цуглуулна.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэрийг бичиж, кодыг “Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код”-оос харж нөхнө.

Тухайн сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, нийтийн байрны хаягийг дэлгэрэнгүй бичнэ.

Мөн тухайн сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, нийтийн байрны байршлыг нийслэл бол 1, аймгийн төв бол 2, сумын төв бол 3, хөдөө бол 4 гэж нөхнө.

Тухайн шинээр барьж ашиглалтад орсон сууцны тусдаа байшин эсвэл нийтийн байрны байршлийн цэгийн мэдээллийг Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн газрийн зураг дээрээс харж бичнэ. Уртраг, өргөргийг бичихдээ бутархайн орноор илэрхийлдэг нэгжийг ашиглана. Таслалын ард 13 орноор бичнэ. ХАӨМС-аас нэг жишээг дор харууллаа.



2. НИЙТ ӨРТӨГ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

1-р мөр: Тухайн шинээр барьсан сууцны тусдаа байшин болон нийтийн байрны өртгийг мянган төгрөгөөр бичнэ.

2-6-р мөр: Тухайн шинээр барьсан сууцны тусдаа байшин болон нийтийн байрны өртөгийг санхүүжилтийн эх үүсвэрээр задлан бичнэ.

3. АШИГЛАЛТАД ОРСОН БАЙШИН/ БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ

Сууцны тусдаа байшин бол 1-р баганад, бие даасан тохилог сууц бол 2-р баганад, нийтийн байр бол 3-р баганад дараах мэдээллүүдийг нөхөж бичнэ. Өөрөөр хэлбэл, нэг айлын хашаанд баригдсан сууцны тусдаа байшингийн мэдээллийг бичих бол зөвхөн 1-р баганад бичих бөгөөд 2, 3-р багана хоосон байна. Учир нь нэг маягтад нэг л байшин/ байрны мэдээллийг оруулна.

Сууцны тусдаа байшин нь ихэвчлэн гэр хорооллын хашаанд байх ба 1, түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.

Бие даасан тохилог сууц /хаус/ нь нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татдаг) байна. Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй, орц, туслах өрөө тасалгаа, дээврийн хөндий, зоорины давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалттай сууц байна. Өөрөөр хэлбэл, бие

даасан тохилог сууцанд сууцны өрөө /унтлагын ба зочны/, гал тогоо, усанд орох онгоц, шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах, ханын шүүгээтэй, мансардтай болон мансардгүй сууцыг хамааруулж ойлгоно. Тусгайлан зөвшөөрөл авч барьсан буюу баригдаж дууссаны дараа Барилгын Улсын комисс хүлээн авсан байшин орохгүйг анхаарна.

Нийтийн байр гэдэгт иргэд бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ амьдран суудаг, олон өрөөтэй сууцыг хамруулна. Нийтийн байр нь ихэвчлэн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүрийг нийтээрээ ашигладаг. Нийтийн байр гэдэгт оюутан, сурагчдын дотуур байр, байгууллагын ажиллагчдын байр орно.

1-8-р мөр: Тухайн байшин/ байр доторх айл амьдрах зориулалттай сууцны/ хаалганы нийт тоог 1-р баганад бичнэ. Нийт сууцны тоог өрөөний тоогоор ялгаж багана 2-8-д нөхнө.

Сууц гэж тухайн байшин дахь нэг гэр бүл аж төрөхөд зориулагдсан нэг буюу хэд хэдэн өрөө бүхий цогцолборыг ойлгоно. Зарим сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц 2 талаасаа ордог тус тусдаа хаалгатай 2 өөр өрх амьдрахаар баригдсан тохиолдолд 1 байшин, 2 сууц гэж үзнэ.

Өрөө гэж сууцны дотор талд байрлах хана, шал, дээврээр тусгаарлагдсан, нийт талбай нь 4 метр квадратаас, өндөр нь 2 метрээс доошгүй хэмжээтэй байна. Өөрөөр хэлбэл, хамгийн багадаа том хүний нэг ор тавих зайтай тасалгааг өрөөнд тооцно. Нийт өрөөний тоонд зочны, унтлагын, хүүхдийн, амралтын, мэргэжлийн болон ажлын, өрөөг оруулна. Туслах өрөө, тасалгаа (гал тогооны, угаалгын, бие засах өрөө, хонгил, ханын шүүгээ, агуулах, тагт) өрөөний тоонд оруулахгүй.

9-р мөр: Тухайн байшин/ байрны давхрын тоог бичнэ. Зоорины давхраас дээш давхрын тоог бичнэ. Үүнд, байшингийн дээврийн хэсэг (мансард)-ийг хүн амьдрах зориулалтаар тохижуулан ашигладаг бол давхрын тоонд оруулна. Харин зоорийн давхар давхарт тоологдохгүй.

10-р мөр: Тухайн байшин/ байрны сууцны, автомашины зогсоолын, үүдний өрөөний зэрэг бүх талбайн нийт хэмжээг квадрат метрээр илэрхийлж бичнэ.

11-р мөр: Сууцны талбайн хэмжээ нь **хүн амьдрах талбай** (амралтын, унтлагын, зочны, хүүхдийн болон ажлын), **туслах өрөө, тасалгаа** (хооллох болон гал тогооны, угаалгын, бие засах өрөө, хонгил, ханын шүүгээ, агуулах)-ны талбайн нийлбэр байна. Тиймээс тухайн байшин доторх сууц тус бүрийн талбайн нийлбэрийг бичнэ.

12-р мөр: Тухайн байшин/ байрны нэг өрөө, давхар, хэсэгт үйлчилгээ явуулах зорилгоор барьсан бол тухайн хэсгийн талбайг бичнэ.

13-р мөр: Дулаан авто зогсоолын талбай гэдэгт байшин/ байрны барилгын авто зогсоолын (дулаан граж) нийт талбайн хэмжээг бичнэ.

14-р мөр: Тухайн байшин/ байр төвлөрсөн цэвэр усны шугамд холбогдсон бол 1, бие даасан систем буюу гүний худгаас усаа байшин/ байранд шууд татдаг бол 2, зөөврийн ус хэрэглэдэг бол 3 гэж нөхнө.

Төвлөрсөн системд холбогдсон усан хангамж. Улсын болон орон нутгийн ус хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас ус түгээх шугамаар дамжуулан хэрэглэгчийг усаар тасралтгүй хангадаг системийг ойлгоно.

Бие даасан системээр холбосон усан хангамж. Улсын болон орон нутгийн ус хангамж хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагаас хамааралгүйгээр тухайн сууцны хэрэгцээг хангах зорилгоор суурилуулан бие даасан байдлаар усаар хангаж байгаа системийг

ойлгоно. Тухайлбал, бие даасан тохилог сууцанд ихэвчлэн тохиолддог хажуудаа гүний худагтай бөгөөд гүний худгаас усны шугам байшинг насосны тусламжтайгаар усаар хангаж байвал үүнд орно.

Зөөврийн. Ус зөөдөг хэрэгслийн төрөл, хэлбэрээс үл хамааран, ус авч байгаа хэлбэр болох усны машинаар зөөвөрлөдөг ус, ус түгээх байр (усны машинаар зөөж хийдэг худаг гэх мэт), гүний худаг (зураг төслийн дагуу малтаж баригдсан мотор буюу бусад төхөөрөмжөөр усаа шууд авдаг худаг), уурхайн худаг (иргэд өөрсдөө малтсан энгийн худаг), усны том саваар хураасан ус, усан сан, суваг, усжуулалтын хоолой, булаг, шанд, гол, мөрөн, нуур зэрэг гадаргийн ус, борооны болон тогтоол усыг хамааруулна.

15-р мөр: Тухайн байшин/ байр төвлөрсөн халуун усны шугамд холбогдсон бол 1, бие даасан систем буюу ус халаах бойлертой бол 2, халуун усгүй бол 3 гэж нөхнө.

16-р мөр: Тухайн байшин/ байр төвлөрсөн ариутгах татуургын шугамд холбогдсон бол 1, бие даасан ариутгах татуурга буюу гаднаа бохир усны цооног эсвэл битүү тунгаагууртай бол 2, гадаа жорлонтой бол 3 гэж нөхнө.

Төвлөрсөн ариутгах татуурга. Хүний ялгадас, бохир ус зэргийг цуглуулан, гадагшлуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам хоолойн системд холбогдсон бие засах газрыг төвлөрсөн ариутгах татуургын шугамд холбогдсон гэж үзнэ. Энэ систем нь бохирыг цуглуулах, шахуургадах, ариутгах, ялгадас бохирыг устгах зориулалттай байгууламжуудаас бүрдэнэ.

Бие даасан ариутгах татуурга. Үүнд соруулдаг бохир усны цооногтой эсвэл битүү тунгаагууртай сууц доторх ариун цэврийн байгууламжийг оруулна.

Бохир усны цооног нь сууцнаас хол, газар дор байрлуулсан, ус нэвтэрдэггүй ялгадас, бохирыг хуримтлуулах савтай бохирын хоолойгоор холбогдсон бие засах газрыг ойлгоно. Хуримтлагдсан бохирыг зөөж халдваргүйжүүлэн цэвэрлэнэ.

Харин *битүү тунгаагуур* гэдэгт бохир усан дахь үл уусах хольц болон шим бодисыг агааргүй орчинд бактерийн тусламжтайгаар эрдэсжүүлэн тунгаах замаар бохир уснаас ялгах тунгаагуур. Тунасан лагийг үе үе юүлж цэвэрлэнэ.

17-р мөр: Тухайн байшин/ байр төвлөрсөн халаалтын шугамд холбогдсон бол 1, уурын зуух бол 2, цахилгаан халаагууртай бол 3, газрын гүний дулааныг ашигладаг бол 4, нам даралтын зуухтай бол 5, ердийн галлагаатай бол 6 гэж нөхнө.

Төвлөрсөн систем Улсын болон тухайн орон нутгийн хувьд дулааны цахилгаан станц, уурын зуухтай холбогдсон дулааны сүлжээтэй сууцыг төвлөрсөн халаалттай гэж үзнэ.

Уурын зуух. Тухайн барилга байгууламжийн халаалтыг шийдэх зорилгоор уурын зуухыг байрлуулан халаалтаа шийддэг бол хувийн уурын зуухаар халаалтаа шийддэг гэж үзнэ.

Цахилгаан халаагуур. Өрхийн хэрэгцээг хангах үүднээс цахилгаан эрчим хүчээр ажилладаг халаах төхөөрөмжийг хамааруулна.

Газрын гүний дулаан. Агаар, газрын хөрс, гол мөрөн нуурын ус, газрын хөрсөн дэх ус тодорхой хэмжээний нам температуртай дулаан агуулдаг бөгөөд дулааны насосны тусламжтайгаар өндөр температур хүртэл өсгөн ашиглах технологи юм. Уг технологийг ашиглан халаалтын эх үүсвэрээ шийддэг бол хамруулна.

Нам даралтын зуух. Нэг болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах үүднээс нэгдсэн халаалтын сүлжээнд ашиглаж буй бага оврын зуухыг үүнд оруулна.

Ердийн галлагаа. Энгийнээр галлаж, халаадаг зуух, пийшинтэй бол хамааруулна.

18-р мөр: Тухайн байшин/ байрны цахилгааны эх үүсвэр нь төвлөрсөн систем бол 1, дизель станц бол 2, сэргээгдэх эрчим хүч бол 3, бага оврын цахилгаан үүсгүүр бол 4, цахилгааны эх үүсвэргүй бол 5 гэж нөхнө.

Төвлөрсөн систем. Хот, суурингийн ихэнх хэрэглэгчдийг нэгдсэн сүлжээний нэг буюу хэд хэдэн эх үүсгүүрээс төвлөрсөн байдлаар цахилгаанаар хангаж байвал төвлөрсөн систем гэнэ. Өөрөөр хэлбэл, улсын цахилгааны шугам сүлжээ болон усан станцаас цахилгаанаа авдаг сууцыг төвлөрсөн систем гэж үзнэ. Цахилгаан станцад холбогдсон цахилгааны сүлжээг (дэд станц) төвлөрсөн систем гэж ойлгоно.

Дизель станц. Тухайн орон нутгийн хувьд бие даасан дизель станцтай холбогдсон цахилгааны сүлжээтэй орон сууцыг хамааруулна. Энд тусгайлан барьсан дизель станцад холбогдсон цахилгааны сүлжээг ойлгоно.

Сэргээгдэх эрчим хүч. Нар салхины эрчим хүчийг хуримтлуулан цахилгаан эрчим хүч болгодог төхөөрөмжийг үүнд хамааруулна.

Бага оврын цахилгаан үүсгүүр. Тухайн нэг өрх болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах зорилгоор шатах болон бусад материалаар ажилладаг бага оврын мотор, цахилгаан үүсгүүрийг үүнд хамааруулна.

19-р мөр: Тухайн байшин/ байрны барилгад автомашины дулаан зогсоолтой бол зогсоолын тоог бичнэ. Хэрэв автомашины дулаан зогсоолгүй бол 0 гэж нөхнө.

20-р мөр: Тухайн байшин/ байрны гаднах хүүхдийн тоглоомын талбайн хэмжээг квадрат метрээр илэрхийлж бичнэ. Хүүхдийн тоглоомын талбайгүй бол 0 гэж бичнэ.

21-р мөр: Тухайн байшин/ байрны гаднах тохижуулсан ногоон талбай буюу мод, цэцэг, ургамал тарьсан талбайн хэмжээг квадрат метрээр илэрхийлж бичнэ. Тохижуулсан ногоон талбайгүй бол 0 гэж бичнэ.

22-р мөр: Тухайн байшин/ байр иргэний өмч бол 1, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмч бол 2, төрийн өмч бол 3 гэж нөхнө.

Балансын шалгалт:

Хүснэгтэд оруулсан мэдээллийн хувьд дараах балансын шалгалтыг заавал хийнэ.

Мөр 1 = Мөр (2:8)

Мөр 10 = Мөр (11:13)